



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дуут сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/160/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэбүрэн хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Гэрээт аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас: 99019943 Цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ДУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЭРДЭНЭХИШИГ ТАНАА

2025.02.20 № 2/38
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дуут сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5.1.3, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Няравын тайлан гаргаагүй, кассаар мөнгө гаргаад анхан шатны баримтагүй зарцуулсан, бараа материалын тооллого хийгээгүй 8,744.8 мянган төгрөг зарцуулсан,
- Хөрөнгөд бүртгэлтэй уурын зуухны газрыг аж ахуйн нэгжид шилжүүлсэн, газрын мэдээллийн санд бүртгэлтэй газруудыг баталгаажуулаагүй,
- Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн хөрөнгийг бүртгэж аваагүй, үндсэн хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй 518,990.0 мянган төгрөг,
- Шатахууны тооцоог бүрэн бодож тооцоогүй, нярав шатахууны тайлан гаргаагүй, замын хуудсаар баталгаажуулаагүй 18,535.2 мянган төгрөг,
- Өвсний тооцоо хийгээгүй 23,774.2 мянган төгрөг
- Засаг даргын нөөц хөрөнгөөс худалдан авсан 24,497.9 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардалд бүртгэсэн,

Асуудлыг онцолсон хэсэг

Улсын болон орон нутгийн төсвөөр хэрэгжүүлсэн БХББЯ/20240101042 гэрээтэй 393,990.0 мянган төгрөгийн өртөгтэй халуун усны барилга, аймгийн ОНХО-аар санхүүжсэн дулааны 125,000.0 мянган төгрөгийн өртөгтэй шугам сүлжээ, нийт 518,990.0 мянган төгрөгийн хөрөнгө орлого аваагүй, төрийн байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй уурын зуухны газрыг сумын ИТХ-ын 2019 7/4 тоот тогтоол, Засаг даргын 2020 оны А/41 тоот захирамжаар аж ахуйн нэгж рүү шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүлэг 8 зорилт 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнан сумын Засаг даргаар дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

Дуут сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

512	Хуримтлагдсан үр дүн	813,873,090.77	943,815,815.78
51210	Өмнөх үеийн үр дүн	813,873,090.77	813,873,090.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	129,942,725.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	242,957,478.27	242,957,478.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,948,341,462.04</u>	<u>2,065,460,866.05</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,073,839,658.00	1,136,183,177.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	456,066,513.00	223,311,777.00
120	Нийтлэг татварын бус орлого	456,066,513.00	223,311,777.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	456,066,513.00	223,311,777.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	35,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	455,461,513.00	222,671,777.00
122	Тусламжийн орлого	-	-
122002	Хандив тусламж /гадаад/	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	617,773,145.00	912,871,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	54,933,145.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,958,545.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,318,100.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,656,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	562,840,000.00	912,871,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	562,840,000.00	912,871,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	750,652,516.75	1,006,240,451.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	750,652,516.75	989,975,751.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	706,192,832.75	951,099,251.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	374,708,292.75	597,931,402.00
210101	Үндсэн цалин	310,489,158.75	423,469,066.00
210102	Нэмэгдэл	64,219,134.00	174,462,336.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,778,852.25	75,892,240.89
210201	Тэтгэврийн даатгал	32,382,364.65	51,629,712.98
210202	Тэтгэмжийн даатгал	3,717,293.09	6,037,689.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,973,834.47	3,675,350.97
210204	Ажилгүйдлийн даатгал	737,655.02	2,742,943.04
210205	Эрүүл мэндийн даатгал	6,967,705.02	11,806,544.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,241,668.51	45,046,076.00
210301	Гэрэл, цахилгаан	4,100,227.51	8,684,800.00
210302	Түлш, халаалт	28,141,441.00	36,361,276.00

Дуут сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	49,817,396.87	36,724,690.00
210401	Бичиг хэрэг	2,707,800.00	3,149,300.00
210402	Тээвэр, шатахуун	14,236,484.87	24,557,390.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,520,000.00	2,932,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,234,600.00	650,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	28,118,512.00	5,436,000.00
2105	Нормативт зардал	326,000.00	945,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	326,000.00	945,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,787,700.00	3,994,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,479,000.00	494,100.00
210604	Урсгал засвар	1,308,700.00	3,500,800.00
2107	Томилолт, зочны зардал	5,396,000.00	7,079,700.00
210702	Дотоод албан томилолт	5,396,000.00	7,079,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,281,897.67	40,341,282.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,004,590.67	38,051,589.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	145,000.00	345,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,000.00	284,929.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000.00	34,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	685,000.00	1,318,070.00
210807	Газрын төлбөр	63,307.00	306,719.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	125,855,024.70	143,143,061.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,002,841.95	38,644,362.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	330,000.00	230,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94,522,182.75	104,268,398.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,459,684.00	38,876,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,278,400.00	38,876,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,703,900.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	37,302,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,574,500.00	1,574,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,181,284.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,181,284.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	16,264,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	16,264,700.00
221001	Их засвар	-	16,264,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>323,187,141.25</u>	<u>129,942,725.01</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>323,187,141.25</u>	<u>129,942,725.01</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	---

Дуут сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,858,135.00	242,957,478.27	813,873,090.77	1,933,688,704.04
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	876,858,135.00	242,957,478.27	813,873,090.77	1,933,688,704.04
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,858,135.00	242,957,478.27	813,873,090.77	1,933,688,704.04
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	129,942,725.01	129,942,725.01
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,858,135.00	242,957,478.27	943,815,815.78	2,063,631,429.05

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	622,163,324.00	924,287,514.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	605,000.00	3,017,921.00
120	Нийтлэг татварын бус орлого	605,000.00	3,017,921.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	605,000.00	3,017,921.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,412,921.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	621,558,324.00	921,269,593.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,718,324.00	9,065,994.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,743,724.00	8,222,904.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,318,100.00	843,090.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,656,500.00	-
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	562,840,000.00	912,203,599.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	562,840,000.00	912,203,599.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	618,511,524.00	924,287,514.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	618,511,524.00	885,411,014.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	565,665,454.00	846,534,514.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	374,482,034.00	596,400,300.00
210101	Үндсэн цалин	208,166,964.00	316,261,064.00
210102	Нэмэгдэл	113,287,305.00	233,320,883.00
210104	Урамшуулал	9,411,840.00	26,377,950.00
210105	Гэрээт ажлын хөлс	43,615,925.00	20,440,403.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,005,111.00	74,657,600.00
210201	Тэтгэврийн даатгал	31,850,511.00	50,767,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,740,300.00	5,962,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,992,700.00	3,057,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	748,300.00	2,925,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,673,300.00	11,945,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,241,668.51	46,960,076.00

Дуут сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210301	Гэрэл, цахилгаан	4,100,227.51	8,684,800.00
210302	Түлш, халаалт	28,141,441.00	38,275,276.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,329,700.00	20,350,924.00
210401	Бичиг хэрэг	2,195,000.00	2,687,700.00
210402	Тээвэр, шатахуун	11,614,700.00	14,333,924.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,520,000.00	3,329,300.00
2105	Нормативт зардал	502,400.00	546,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	502,400.00	546,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,867,600.00	1,904,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	280,600.00	317,000.00
210604	Урсгал засвар	1,587,000.00	1,587,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,396,000.00	7,079,700.00
210702	Дотоод албан томилолт	5,396,000.00	7,079,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,599,845.00	20,709,914.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,242,538.00	18,820,291.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	145,000.00	345,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,000.00	284,929.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	34,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	765,000.00	918,000.00
210807	Газрын төлбөр	63,307.00	306,719.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,241,095.49	37,000,871.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,541,095.49	35,516,871.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	700,000.00	1,484,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,846,070.00	38,876,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,278,400.00	38,876,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,703,900.00	-
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	37,302,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,574,500.00	1,574,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,181,284.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,181,284.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,386,386.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,386,386.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,651,800.00</u>	<u>77,925,200.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,651,800.00	77,925,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,651,800.00	77,925,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,651,800.00	77,925,200.00
221001	Их засвар	-	17,800,000.00
222001	Тоног төхөөрөмж	3,651,800.00	60,125,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(3,651,800.00)</u>	<u>(77,925,200.00)</u>

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	913,476,400.00	912,808,599.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	835,551,200.00	834,883,399.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	796,674,700.00	796,006,899.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	597,258,900.00	597,258,900.00
210101	Үндсэн цалин	324,265,400.00	324,265,400.00
210102	Нэмэгдэл	233,167,800.00	233,167,800.00
210104	Урамшуулал	16,065,700.00	16,065,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,760,000.00	23,760,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,657,600.00	74,657,600.00
210201	Тэтгэврийн даатгал	50,767,000.00	50,767,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,972,600.00	5,972,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,986,400.00	2,986,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,986,400.00	2,986,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,945,200.00	11,945,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,460,100.00	47,460,100.00
210301	Гэрэл, цахилгаан	8,684,800.00	8,684,800.00
210302	Түлш, халаалт	38,775,300.00	38,775,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,648,000.00	19,648,000.00
210401	Бичиг хэрэг	2,712,000.00	2,712,000.00
210402	Тээвэр, шатахуун	13,606,700.00	13,606,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,329,300.00	3,329,300.00
2105	Нормативт зардал	553,700.00	553,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	553,700.00	553,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,904,000.00	1,904,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317,000.00	317,000.00
210604	Урсгал засвар	1,587,000.00	1,587,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,156,700.00	7,156,700.00
210702	Дотоод албан томилолт	7,156,700.00	7,156,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,488,100.00	12,488,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,597,600.00	10,597,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	346,000.00	346,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	285,000.00	285,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	34,000.00	34,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	918,000.00	918,000.00

Дуут сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210807	Газрын төлбөр	307,500.00	307,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,547,600.00	34,879,799.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,063,600.00	33,395,799.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,484,000.00	1,484,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,876,500.00	38,876,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,876,500.00	38,876,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,302,000.00	37,302,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,574,500.00	1,574,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	77,925,200.00	77,925,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	77,925,200.00	77,925,200.00
222001	Тоног төхөөрөмж	77,925,200.00	77,925,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	913,476,400.00	912,808,599.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	912,871,400.00	912,203,599.00
132001	Орон нутгийн төсвөөс	912,871,400.00	912,203,599.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	605,000.00	605,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,456,285.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,456,285.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,456,285.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,456,285.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,456,285.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,456,285.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,456,285.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,578,195.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	783,090.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	95,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 808,092.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 639,019.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн тайланд үнэ төлбөргүй орлого буруу бүртгэсэн 100,464.2 мянга,
- Мөнгөн хөрөнгийн орлого буруу илэрхийлсэн 8,880.7 мянга,
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлээдээгүй 368,544.9 мянга,
- Байдлын тайланд мөнгөн хөрөнгийг 4,354.8 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэж нягтлан бодох бүртгэлийн стандарт хэрэгжүүлээгүй байгааг залрууллаа.

Залруулагдаагүй 157,352.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 157,352.5 мянган төгрөгийн 11 зөрчил² илэрснээс, орлого төвлөрүүлээгүй 2 зөрчилд 1 төлбөрийн акт, өвсний тооцоо хийх, худалдан авах ажиллагаа зохион байгуулах, мөнгө баримтгүй зарцуулсантай холбоотой 134,943.2 мянган төгрөгийн 3 зөрчилд 1 албан шаардлага, хөрөнгө орлого авах, газрын асуудал шийдвэрлэх, шатахуун зарцуулалт, төсөвтэй холбоотой 22,410.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт: Аймгийн онцгой комиссын 2023.03.01/05 тоот тогтоолоор сумдад хөнгөлөлттэй үнээр олгосон өвс, тэжээлийн үнийн зөрүү болох 11.6 сая төгрөгийг аймгийн орлогод төвлөрүүлээгүй, ирсэн өвс, тэжээлийн авлага, өглөгийн тооцоо хийж баталгаажуулаагүй, нярвын тайлан гаргаагүй,

5.1.2 Илрүүлэлт: Түрээсийн орлого төвлөрүүлээгүй, түрээсийн гэрээ байгуулж гэрээгээ дүгнээгүй орон нутгийн төсөвт 40%-ийг төвлөрүүлээгүй 120.0 мянган төгрөгийн зөрчил тус тус илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020.02.18-ны 49 тоот тогтоолын 2-т зааснаар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

5.2.1 Илрүүлэлт: Нөөц хөрөнгийн дансанд худалдан авсан 23.7 сая төгрөгийн өвс тэжээлийг орлого аваагүй, 24.5 сая төгрөгийн өмнөх оны өвсний тооцоо хийж үлдээдлийг баталгаажуулаагүй, нярав нөөц хөрөнгийн тайлан гаргаагүй, өмнөх оны үлдээдлийг шууд зарлагдсан 48.3 сая төгрөг,

5.2.2 Илрүүлэлт: Хөрөнгө оруулалтын зардлаас 77.7 сая төгрөгийн зарцуулалтыг тендер зарлаагүй, харьцуулалтын аргаар шалгаруулж гэрээ хийгээгүй шууд худалдан авалтаар хөрөнгө бэлтгэсэн,

5.2.3 Илрүүлэлт: Баяр наадмын зардалд нярваар дамжуулан бэлэн мөнгө зарцуулсан ч нярвын тайлан гаргаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн 8.7 сая төгрөг зэрэг зөрчлүүд илэрлээ.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага бичих

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Газартай холбоотой асуудал

Илрүүлэлт: Уурын зуухны барилга ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй байхад газрын нэгдсэн сангийн мэдээлэлд байгаа газрыг ИТХ-ын 2019/07/04/7/4 тоот тогтоол, ЗД-ын 2020/04/20/A/41 захирамжаар аж ахуйн нэгжид шилжүүлсэн байна. Нэгдсэн сангийн мэдээлэлд байгаа 5 газраас 2 газар данс бүртгэлд бүртгээгдсэн, 3 газар бүртгээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"

Өгсөн зөвлөмж: ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй уурын зуухны газрыг аж ахуйн нэгжид ИТХ-ын тогтоолоор шилжүүлсэн байгааг эргэн нягталж шийдвэрлэх, ээрчилгээтэй газрын тулгалт хийж хөрөнгөд бүртгэх

5.3.2. Төсөв зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тамгын газрын санхүүжилтээс төсөвт тусгагдаагүй ИТХ-ын даргад тавилга худалдан авсан 3.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах

5.3.3. Хөрөнгө оруулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: 202-2024 онд УТХО, ОНХО-аар хийгдсэн халуун усны барилга 393.9 сая, шугам сүлжээ шинэчлэх оролцоо 125.0 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсан актаар баталгаажуулан ашиглалтад оруулсан ч шийдвэргүй тул хөрөнгө орлого аваагүй зөрчил илэрлээ

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцээгүй

Өгсөн зөвлөмж: Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хариуцлагатай хандаж хөрөнгө орлого авах талаар санаачилгатай ажиллах

5.3.4. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын орон нутгийн хөгжлийн сангаас өгсөн шатахууны зардлыг замын хуудсаар баталгаажуулаагүй, нярав шатахууны тайлан гаргаагүй, санхүүгийн баримт эмх цэгцгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 18.5 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Шатахууны зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлэх, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд үнэ төлбөргүй орлого буруу бүртгэсэн 100.6 сая, мөнгөн хөрөнгийн орлого буруу илэрхийлсэн 8.8 сая, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй 368.5 сая, байдлын тайланд мөнгөн хөрөнгийг 4.3 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэж нягтлан бодох бүртгэлийн стандарт хэрэгжүүлээгүй	1	482,244.6	1	482,244.6			1	482,244.6	-	-
Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор аваагүй, хөрөнгийг ангилж стандартын дагуу бүртгээгүй	1	156,775.2	1	156,775.2			1	155,775.2		
Дүн	2	639,019.8	2	639,019.8			2	639,019.8		

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

АОК-ын 2023.03.01/05 тоот тогтоолоор хөнгөлөлттэй үнээр олгосон өвс, тэжээлийн үнэ төвлөрүүлээгүй, өвсний авлага, өглөгийн тооцоо хийж баталгаажуулаагүй, орлого авч зарлага гаргасан баримт хангалтгүй	1	11,600.0	1	11,600.0				
Түрээсийн орлого төвлөрүүлээгүй, түрээсийн гэрээ байгуулж тооцоо хийгээгүй /40%/		120.0		120.0				
Нөөц хөрөнгийн дансанд 23.7 сая төгрөгийн өвс тэжээлийг орлого аваагүй, 24.5 сая төгрөгийн өмнөх оны өвсний тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, нярав нөөц хөрөнгийн тайлан гаргаагүй, хөрөнгө шууд зарлагдсан		48,272.2			1	48,272.2		
Хөрөнгө оруулалтын зардлаас 77.7 сая төгрөгийн зарцуулалтыг тендер зарлаагүй, харьцуулалтын аргаар гэрээ хийгээгүй шууд худалдан авалтаар хөрөнгө бэлтгэсэн байна	1	77,925.2			1	77,925.2		
Баяр наадмын зардалд нярваар дамжуулан бэлэн мөнгө зарцуулсан ч нярвын тайлан гаргаагүй, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн		8,744.8				8,744.8		
Уурын зуухны барилга ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй байхад газрын нэгдсэн сангийн мэдээлэлд байгаа газрыг ИТХ-ын 2019/07/04/7/4 тоот тогтоол, ЗД-ын 2020/04/20/А/41 захирамжаар аж ахуйн нэгжид шилжүүлсэн байна. Нэгдсэн сангийн мэдээлэлд байгаа 5 газраас 2 газар данс бүртгэлд бүртгэгдсэн, 3 газар бүртгээгүй байна	1	0					1	0
Тамгын газрын санхүүжилтээс ИТХ-ын даргад тавилга худалдан авсан бөгөөд авлагаар тусгаагүй	1	3,875.0					1	3,875.0
2023-2024 онд УТХО, ОНХО-аар хийгдсэн халуун усны барилга 393.9 сая, шугам сүлжээ шинэчлэх оролцоо 125.0 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсан актаар баталгаажуулан ашиглалтад оруулсан ч шийдвэргүй тул хөрөнгө орлого аваагүй	1	0					1	0
Сумын орон нутгийн хөгжлийн сангаас өгсөн шатахууны зардлыг замын хуудсаар баталгаажуулаагүй, нярав шатахууны тайлан гаргаагүй, санхүүгийн баримт эмх цэгцгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй	1	18,535.2					1	18,535.2
Дүн	6	169,072.4	1	11,720.0	1	134,942.2	4	22,410.2

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс
--------------------	-------------	--------

			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Дуут сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1	2	3	4	5	6	7	8	9
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг хянасан зөрчил илрээгүй		-	-	-	-	-	-	-

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Х.Болдбаатар* Х.БОЛДБААТАР 2025.02.18

АУДИТЫН МЕНЕЖЕР *А.Цэцэгсүрэн* А.ЦЭЦЭГСҮРЭН 2025.02.18

ГЭРЭЭТ АУДИТОР *Д.Эрдэнэцэцэг* Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ 2025.02.18